



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/330

Биебүлэг

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2024 оны 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зудын улмаас хорогдсон малын сэг, зэмийг устгах ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлыг хэвсралтаар баталсугай.

2.Хорогдсон малын сэг, зэмийн устгалын үйл ажиллагаанд хяналт тавьж үр дүнтэй зохион байгуулахыг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах), Онцгой байдлын газар (дэд хурандаа Ц.Лувсанжамц)-т тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх зардалд шаардагдах 17,000,000 (арван долоон сая) төгрөгийг Улсын Онцгой комиссоос хуваарилсан эх үүсвэрээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын *2024* оны
09 дүгээр сарын *01*-ний өдрийн *330* дугаар
захирамжийн хавсралт



ХОРОГДСОН МАЛЫН СЭГ, ЗЭМ УСТГАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Товч утга	Мөнгөн дүн
1	Дэлгэр сумын малын сэг, зэм устгах ажилд зарцуулагдах зардал	9,600,000
2	Чандмана сумын малын сэг, зэм устгах ажилд зарцуулагдах зардал	1,800,000
3	Халиун сумын малын сэг, зэм устгах ажилд зарцуулагдах зардал	2,000,000
4	Дэлгэр, Чандмань, Бигэр, Халиун сумдад ажилласан ажлын хэсгийн албан томилолт	3,600,000
	Дүн	17,000,000

__оОо__